



“Доров дэхь засаглал” хэмээх цаасан малгай омсгон хооргож, оорсдийнхоо бvх торлийн сурталчилгааг vнэ холсгvй, одоржин, шоножин цацуулдаг Монголын улсторчид эрх мэдэлд хvрэх замыг нь засч огсон хэвлэл мэдээллийн салбар, хэдэн муу ядуухан сэтгvүлчид рvүгээ эргээд ноцож, харцаараа ходолгодог болгохоор хамгийн хорлонтой хуулийн тосол бэлэн болгочихоод сууцгааж байна. Энэ хаврын чуулганаар хэлэлцэн батлуулахаар шийдлийн Засгийн газрын Хууль зvйн сайд Д.Дорлигжавын яаравчлуулж байгаа Эрvүгийн болон Зорчлийн тухай хууль батлагдвал оноодрийн ядуухан сэтгvүлчид эдийн засаг, санхvүгийн хувьд бvрэн дампуурахаас оор ямар ч зам харагдахгvй болж байна. Ядаж байхад Засгийн газраас оргон барьсан хуулийн тосолд сэтгvүлчдэд Эрvү үүсгэж хорих хуулийн заалт ч багтаж байгаа. Хэдийгээр сvүлийн жилvүдийн замбараагvй их авлига, хээл хахууль, албан тушаалын гэмт хэрэгтнvүдийг удаа дараа илчлэн бичиж, олон цагаан захтнуудыг шударга шvүхийн омно аваачсан гавьяа оор хэнд ч биш хэвлэл мэдээллийн байгууллагууд, тэнд ажилладаг цалин багатай ч эр зоригтой, нийгмийнхээ омно хvлээсэн vүргээ нэр төртэй биелvүлж яваа хэдэн сэтгvүлчдэд хамаатай ч тор засгаасаа эхлээд, олон нийтийн сэтгэл зvй ероосоо л муу муухай бvхнийг

сэтгүүлчдэд тохож, тэдний нэр хvндийг гутаан доромжлох агуу их компанит ажил орон даяар орноод удаж байна. Ядахад яр гэгчээр нийгмийн бvх л муу муухай, хошигний арын болж бvтэхгvй бvхнийг илчлэн гаргадаг оноо хэдэн сэтгvвч рvв одоо улсторчид, тор засагтайгаа элбэж аваад дайрч эхлэхээр эргэлт буцалтгvй шийдсэн бололтой.

Учир нь Цагаан сарын омнохон Хууль зvйн сайд Д.Дорлигжав Эрvвгийн болон Зорчлийн тухай хуулийн тослийг УИХ-д оргон мэдvвлсэн билээ. Эдгээр хуульд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбоотой маш ноцтой заалтууд тусгагдсанаас цоон хэдэн баримтыг дурдъя.

Зорчлийн тухай хуулийн тослийн 10.4.3-т “Мэдээлэх хэрэгсэл ашиглан сурвалжлага, мэдээ, тоймчийн нийтлэл болон зар сурталчилгааны бус хэлбэрээр зар сурталчилгаа байрлуулсан, тvгээсний толоо монго авсан бол хувь хvнийг 250 тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний тогроогоор, хуулийн этгээдийг 2500 тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний тогроогоор торгох ял шийтгэнэ” гээд заачихсан байна. Оноодор улс орны эдийн засгийн хvндрэлтэй, одор хоног арай ядан аргацааж байгаа нохцолд одор тутмын сонин, телевиз, богино долгионы радионууд чухамдаа зар сурталчилгаан дээр л аргацаан тогтож, чадан ядан вйл ажиллагаагаа залгуулж байгаа гэдгийг насаараа дарга хийж яваа Хууль зvйн сайд ойлгохгvй байж болно. Магадгvй тэр хvн баримт нотолгоо сайтай ганц мэдээ бичихийн тулд сонины сурвалжлагч одоржин явган, нvцгэн шогшдогийг яагаад ч гадарлахгvй нь тодорхой. Ганц ярилцлага авахын тулд ороонийх нь хаалгыг одоржин сахидаг сэтгvвчдийн хагас сард авдаг цалингаар ганц, хоёрхон хоног хооллодог байж ч мэднэ. Гэхдээ эрх мэдлээрээ далайлган бvхэл бvтэн хэвлэл мэдээллийн салбарын дотоод вйл ажиллагаа, хэвлэн нийтлэх эрх чолоонд дур зоргоороо халдах эрх байхгvй.

Д.Дорлигжав сайдын оргон мэдvвлсэн Эрvвгийн болон Зорчлийн тухай хуулийн тосолд vнээс ч илvв бас нэгэн ноцтой заалт байгаа нь Зорчлийн тухай хуулийн 10.4.1 дэх заалт юм. Тэнд “Сэрэмжлvвлэг зар сурталчилгааг тухайн хэвлэл мэдээллийн хэрэгслийн нэвтрvвлгийн хотолборийг харгалзалгvйгээр холбогдох шийдвэрт заасан давтамжаар vнэ толборгvйгээр тvгээгээгvй бол хувь хvнийг 250 тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний тогроогоор, хуулийн этгээдийг 2500 тооцооны нэгжтэй тэнцэх хэмжээний тогроогоор торгох шийтгэл хvлээлгэнэ” гээд цагаан дээр хараар биччихсэн байна. Уг заалттай, заалтгvй бид сэрэмжлvвлэх мэдээгээ хангалттай бичиж, нийтэлж, нэвтрvвлж ирсэн. Vvнийг хуульчлаад байх шаардлага огт байхгvй. Vvгээр бол санаандгvй ганц мэдээ нийтлэхгvй орхиход торгуулж мэдэхээр байна. Гэхдээ уг заалт нь арай оор зvйлд чиглэгдэж байна уу гэдэг хардлагыг торvвлж байгаа нь эрх баригчид дуртай шийдвэрvвдээ гаргуулчихаад тvвнийгээ сэрэмжлvвлэх зар сурталчилгаа нэрээр хvссэн хэвлэл мэдээллийн хэрэгслээрээ явуулах эрхийг нээх гэж байна хэмээн сэтгvвчид vзэж байгаа юм. Оноодор улсын омчид vлдсэн хэвлэл мэдээллийн хэрэгсэл ганц, хоёрхон бий. Бараг бvгд хувьд шилжиж, эзэд нь хэдэн сурвалжлагч, сэтгvвчдээ ажилтай, орлоготой

нэг юм чирээд явж байгаа. Гэтэл тороос хувь хишиг горьдолгвй оорсдийгоо аргацаагаад явж байгаа хувийн омчийн вйл ажиллагаанд тор шууд хутгалдан орох гэж байна. Бvр давраад шийдвэрvндийг нь хэрэгжvвлээгvй тохиолдолд тооцооны нэгжээр торгоно гэдэг жигтэйхэн зvйл ярьж байгаа нь хэвлэл мэдээллийн хэрэгслvвдийн дотоод вйл ажиллагаанд дэндvв эрээ цээргvй хутгалдан орж ирж байгаа хэрэг юм. Тооцооны нэгж гэдэг нь ам.доллартай уялдуулан торгох гэсэн vг. Эдийн засаг хямрангуут сэтгvвлчдээ хvртэл ам.доллартай тэнцэх хэмжээний монгоор торгож эхлэх нь. Энэ нь оороо хууль зорчсон вйлдэл богоод хуульд "Монголдоо аливаа торгууль, худалдааг vндэсний монгон тэмдэгтээр гvйцэтгэнэ" гээд заачихсан байгаа.

Тvвнчлэн Эдийн засгийн оршоолийн хуульд авлигачдыг илрvвлэн бичсэн сэтгvвлчдийг 5-50 сая тогрогоор торгоно гэсэн заалтыг хvртэл оруулчихаад явж байна. Оноодор Монголд авлига, хээл хахуульд хэн орооцолдож, хэдэн цагаан захтан оноодор тэрбум, тэрбумаар хулгайлсныхаа толоо хоёр гуравхан жил эрхээ хасуулсан болчихоод малилзсаар гарч ирж байгааг олон нийт харж л байгаа. Vнэндээ эдийн засаг нь элгээрээ хэвтчихээд босох тэнхэлгvй тийчилсээр байгаа Монголын улсторчид, эрх мэдэлтнvвдийн булхай луйврыг оор хэн ч биш оноо муу хэдэн муу нэртэй сэтгvвлчид л нийгэмд хамгийн тvрvвнд дэлгэн тавьдаг. Тvвнийхээ толоо хангалттай муу нэр зvвж, шvвх цагдаагийн байнгын вйлчлvвлэгчид болсоор байгаа нь Хууль зvйн сайд эрхэм Д.Дорлигжавт багадаад байгаа бололтой юм. Магадгvй Эрvвгийн болон Зорчлийн тухай хуулийн тослийг Д.Дорлигжав сайд найруулан бичиж, гол санааг нь гаргаж ирээгvй байж болно. Гэхдээ Монголын нийгмийг эрvвжvвлж, булхай луйвар бvхний эсрэг vзэг, камер, дэвтэрнээс оор зэвсэггvй чин сэтгэл, залуу насны эр зоригоор унаж, босон тэмцэж яваа тоотой хэдэн сэтгvвлчийн эрх ашигт ноцтой хохирол учруулах дээрх хуулийг буцаан татах эрх нь тvвнд хангалттай бий.

Хуулийн дор бvгд эрх тэгш гэсэн уриа лоозонгийн шинжтэй тунхаглал ярьж суухаар хэвлэлийн эрх чолоог боомилон дарж, хэдэн муу сэтгvвлчийг ажиллах нохцолгvй болгох гэж байгаа Эрvвгийн болон Зорчлийн тухай хуулийн ядаж л дээрх хэдэн ноцтой заалтыг авч хаях эрх мэдэл, хvсэл зориг Хууль зvйн сайдад байгаа болов уу гэж найдах л vлдэж байна. Эрх баригчид, улсторчид, цагаан захтнууд дураараа авирлахын тулд сэтгvвлчдийг хуулийн заалтаар нухчин дарж хэвлэлийн эрх чолоогvй орон болохгvйн тулд Эрvвгийн болон Зорчлийн тухай хуулийг эргэж сайтар нягтлахыг эрхэм Хууль зvйн сайдаас хvсч байна.

Эх сурвалж:

Â

Top of Form

Â

Â